



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ

2018

ХУУЛЬ ЗҮЙН
СУДАЛГААНЫ
ТӨВ

Судалгааны захиалагч:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн

Судалгааг удирдсан:

П.Амаржаргал ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Алтансүх ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр

Х.Дөлгөөн ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг хянасан:

С.Энхцэцэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

ГАРЧИГ

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	3
1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага	3
1.2. Үнэлгээ хийх хүрээ	4
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	4
1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	4
1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	5
1.3.3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	6
1.3.4. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	7
1.4. Үнэлгээний арга зүй	8
1.5. Судлагдсан байдал	8
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	9
2.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	22
2.3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	24
2.4. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	29
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	34
НОМ ЗҮЙ	38

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэж заасан. Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулахаар тусгажээ.

Энэхүү үндэслэл, шаардлагын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн захиалгын дагуу Шүүхийн шинжилгээний тухай хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу энэхүү үнэлгээг гүйцэтгэлээ.

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд хэрэгжиж эхэлснээс хойш 9 жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуульд нийтдээ 5 удаа нэмэлт, өөрчлөлт хийсэн байна.¹ Эдгээр өөрчлөлтийн тухайд уг хуулийн агуулга, үзэл баримтлалыг өөрчлөхөд бус, харин бусад хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж хийгдэж байсан өөрчлөлт болсон нь харагдаж байна.

Энэ хууль батлагдсанаар шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндэс бүрдэхэд чухал ач холбогдолтой болсон боловч практикт зарим тулгамдсан асуудал гарсаар байна.

Тухайлбал, Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу Монгол Улсын Их Хурлаас Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тус тус баталсан. Үүнтэй холбогдуулан шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага хоорондын чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинээр авч үзэх шаардлага гарсантай уялдуулан дээрх хуулиудад нийцүүлэн Шүүхийн шинжилгээний тухай хуулийг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Нөгөө талаас Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны

¹ <http://www.legalinfo.mn/law/details/88> Сүүлд үзсэн огноо: 2018.03.10.

үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.” гэж заасан боловч энэхүү байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдал зэрэгт зарим тулгамдсан асуудал гарч байна.

Түүнчлэн, Шүүхийн шинжилгээний тухай хуульд эрүү, иргэн, захиргааны хэрэгт хийх шинжилгээний зарим онцлог төрлүүдийг нарийвчлан тусгаагүй бөгөөд нийгмийн хөгжлийг даган инженер техник, байгаль экологи, цахим төхөөрөмж гэх мэт шинжилгээний бусад төрлүүдийг хэрхэн хийх тухай зохицуулалтыг тусгах шаардлага тулгарч байна. Үүнээс гадна дээрх төрлийн шинжилгээг хийхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дэд бүтэц, хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх нь тулгамдсан асуудал хэвээр байна. Иймд энэхүү судалгаагаар дээр дурдсан зарим асуудлын талаар судалж, үнэлгээг хийх болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Шүүхийн шинжилгээний тухай хууль батлагдсанаас хойш энэ хуулийн хэрэгжилтэд гарч буй тулгамдсан асуудлын талаар төрийн эрх бүхий байгууллага, иргэд, мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдын зүгээс зарим санал, шүүмжлэл гарч байжээ. Эдгээр тулгамдсан асуудлыг тоймлон авч үзвэл 1/ Шүүхийн шинжилгээний байгууллага, түүний тогтолцоо, шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн байдал; 2/ Шүүхийн шинжилгээг хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн орчин; 3/ Зарим төрлийн шинжилгээний онцлог; 4/ Шинжилгээ хийх хугацаа зэрэг болно.

Энэхүү судалгаагаар Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 11 дүгээр зүйл, 24-27 дугаар зүйл, 37 дугаар зүйл, 39 дүгээр зүйл, 43 дугаар зүйл гэсэн зүйл, заалтыг тус тус сонгож, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон болно.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтэд гарч буй тулгамдсан асуудлын нэг бол шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухай асуудал юм. Үүнээс гадна шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн эрх зүйн байдлыг сайжруулахтай холбогдсон асуудал юм. Иймээс эдгээр асуудлыг зохицуулж буй хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийг судалж, тухайн зохицуулалтын эерэг болон сөрөг үр дагаврыг тодруулан үнэлгээг хийнэ. Ингээд сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	37 дугаар зүйл	<p>Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо</p> <p>37.1.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.</p> <p>37.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ.</p> <p>37.4.Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.</p>
2	39 дүгээр зүйл	<p>Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт</p> <p>39.1.Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</p>
3	43 дугаар зүйл	<p>Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа</p> <p>43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.</p> <p>43.2.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.</p> <p>43.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.</p>

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 1 дүгээр зүйлд тусгаснаар энэ хуулийн зорилтыг “... шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, зарим төрлийн шинжилгээний онцлог болон шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн

эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тусгажээ. Ингээд эдгээр зорилтыг хангахдаа энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт шүүхийн шинжилгээг хийхдээ хараат бус байх зарчмыг баримтална гэж тусгасан.

Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн хараат бусаар чиг үүргээ гүйцэтгэх эрх зүйн орчныг бий болгох нь энэхүү хуулийн 1 дүгээр зүйлд тусгасан зорилтыг хангахад чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Иймд энэхүү хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт тусгасан “хараат бус байх” гэсэн зарчмын хэрэгжилтийг “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийхээр сонгосон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	4 дүгээр зүйл	Шүүхийн шинжилгээний зарчим 4.1.Шүүхийн шинжилгээ хийхэд дараахь зарчмыг баримтална: 4.1.3.хараат бус байх;

1.3.3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд зарим төрлийн шинжилгээний онцлогийг тусгасан. Эдгээрт криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц болон эдийн засгийн шинжилгээний төрлүүд хамаардаг. Энэ нь одоогийн шүүхийн шинжилгээнд чухал байр суурийг эзэлж байгаа боловч нийгэм, эдийн засгийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, хот суурин газрын төвлөрөл зэргээс хамааран сүүлийн үед гарч буй гэмт хэрэгт байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн гэх мэт шинэ төрлийн шинжилгээг хийх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Үүнээс үүдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн бодит байдлыг тогтоохын тулд дээр дурдсан шинэ төрлийн шинжилгээг хуульд нарийвчлан тусгаж өгөх шаардлага бий болсон нь харагдаж байна. Иймд энэхүү хуулийн 24-27 дугаар зүйлд заасан зарим төрлийн шинжилгээний онцлог, түүний хэрэгжилтийг “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийхээр тогтоосон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	24 дүгээр зүйл	Криминалистикийн шинжилгээ
2	25 дугаар зүйл	Шүүх эмнэлгийн шинжилгээ
3	26 дугаар зүйл	Сэтгэцийн шинжилгээ
4	27 дугаар зүйл	Эдийн засгийн шинжилгээ

1.3.4. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Шүүхийн шинжилгээний байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц, эдийн засаг болон тусгай төрлийн шинжилгээг хийж, дүгнэлт гаргаж байна. Мөн хуульд заасны дагуу шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зүгээс дээр дурдсан шинжилгээг хийж, дүгнэлт гаргах хугацааг тогтоохдоо тухайн шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог зэргийг харгалзан үзэлгүй, шинжилгээний төрөл бүрт нийтлэг хугацааг тогтоож байгаа нь шинжилгээний дүгнэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймээс тухайн шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог, цар хүрээ зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр шинжилгээ хийх хугацааг харилцан адилгүй байдлаар тогтоож өгөх нь шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх зарчмыг хангахад чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Иймд энэхүү хуулийн 11 дүгээр зүйлд тусгасан “шинжилгээ хийх хугацаа”-г “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийхээр шалгуур үзүүлэлтийг тогтоосон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 4. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	11 дүгээр зүйл	Шинжилгээ хийх хугацаа 11.1.Шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг шүүхийн шинжилгээний байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн шинжилгээ хийж дуусгах хугацааг

		тооцно. 11.2.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно. 11.3.Шинжээч нь энэ хуулийн 11.2-т заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол шинжилгээ хийх хугацааг сунгуулах тухай хүсэлтээ шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргана. 11.4.Энэ хуулийн 11.3-т заасан хүсэлтийг хүлээн авсан этгээд шүүхийн шинжилгээ хийх хугацааг мөн хуулийн 11.2-т заасныг үндэслэн сунгана.
--	--	---

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хийж гүйцэтгэв. Түүнчлэн шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, бүтэц, бүрэлдэхүүн, бусад тулгамдаж буй асуудлыг судлахдаа харьцуулах, түүхчлэх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх гэсэн хууль зүйн судалгааны үндсэн арга зүйг ашигласан.

Түүнчлэн, шүүхийн шинжилгээний байгууллагад гарч байгаа тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд өмнө хийгдэж байсан зарим судалгааны үр дүн, мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтнуудаас авсан социологийн судалгааны үр дүнг ашигласан болно.

1.5. Судлагдсан байдал

Шүүхийн шинжилгээний тухай хууль 2009 онд батлагдсанаас хойших хугацаанд тус хуулийн хэрэгжилтийг үнэлсэн цогц судалгаа хийгдээгүй байна. Гэсэн хэдий боловч энэ хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2015 онд хийсэн “Шүүх шинжилгээ” сэдэвт судалгаа, мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн зарим ажилтан, албан хаагчдын гүйцэтгэж байсан судалгаа, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл зэргийг дурдаж болно.

Мөн уг судалгааны эх сурвалжийн мэдээллийн бодитой байдлыг хангах үүднээс 2017 онд хэвлэгдсэн Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016, түүнчлэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2013 оноос эрхлэн гаргаж буй “Шүүхийн шинжилгээний статистик” гарын авлага, 2016 оноос эрхлэн гаргаж буй “Шүүхийн шинжилгээ” практик, танин мэдэхүйн сэтгүүл болон тус хүрээлэнгийн 2009-2017 оны үйл ажиллагааны тайлан, мөн газар, хэлтэс, нэгжүүдээс ирүүлсэн танилцуулга, мэдээлэл зэрэг эх сурвалжуудыг ашиглалаа.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

37 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо

39 дүгээр зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт

43 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа

1. Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо

Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталсан.² Энэхүү хөтөлбөрийн 44 дүгээр зүйлд “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх-эмнэлэг, санхүү, нягтлан бодох бүртгэл зэрэг магадлан шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтад оруулан материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна.” гэж тусгасан.

Энэ ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Криминалистикийн шинжилгээний хүрээлэнг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулсан.³

Үүний дараа Засгийн газрын 2007 оны 270 дугаар тогтоолын дагуу Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн эмч нарыг нэгтгэн “Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба”-ыг байгуулсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 19 дүгээр тогтоолд заасны дагуу тус байгууллагыг “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн” болгож үйл ажиллагааг өргөжүүлсэн.⁴ Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг шинэчлэн баталсан. Үүнд:

- Захиргаа, удирдлагын газар;
- Санхүү төлөвлөлт, хангамжийн газар;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс;

² <http://www.legalinfo.mn/annex/details/3140?lawid=6881> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

³ Ч.Алтанхишиг, “Шүүхийн шинжилгээний байгууллагын түүхэн хөгжил, хөгжлийн чиг хандлага, үйл ажиллагаанд тулгамдсан асуудал”, *Шүүхийн шинжилгээ эмхэтгэл*, Дугаар 4, (2017), 5 дахь тал.

⁴ <http://nifs.gov.mn/?/page/12.jsp> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

- Криминалистикийн шинжилгээний газар;
- Шүүх эмнэлгийн шинжилгээний газар;
- Тусгай шинжилгээний газар;
- Эдийн засгийн шинжилгээний хэлтэс;
- Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс;
- Аймаг, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, алба, тасаг, хэсэг” гэсэн бүтэцтэй буюу 6 газар, 3 хэлтэс, 7 тасаг, 22 алба, 8 хэсэгтэй, 514 албан хаагчийн орон тоотой батлагджээ.⁵

Шүүхийн шинжилгээний тухай хуульд 2009 онд батлагдсанаас хойш нийтдээ таван удаа нэмэлт, өөрчлөлт орсон тухай дээр дурдсан. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь тухайн хуулийн үзэл баримтлалыг тодотгосон шинжтэй болсон байна. Мөн шинээр батлагдсан хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор уг хуулинд өөрчлөлт оруулж байжээ.

Тухайлбал, Улсын Их Хурлаас Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг шинэчлэн баталсантай холбогдуулан шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага хоорондын чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинээр авч үзэх шаардлага гарсныг харуулж байна. Ингээд шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, түүний эрх зүйн байдалтай холбоотой тулгамдсан асуудлын талаар дор дэлгэрүүлэн авч үзье.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ.” гэж тусгасан. Үүнээс харахад энэхүү хуульд шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцооны талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Өөрөөр хэлбэл шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, албан хаагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тусгаагүй бөгөөд энэхүү харилцааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 82 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм”-д зааснаар зохицуулж байна.

Үүнээс үүдэн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа энэ байгууллагын удирдлага, түүний зохион байгуулалт, ажилтан албан хаагчийн эрх зүйн байдалд сөрөг үр дагавар үүсч болзошгүй байдал гарч байна.⁶

Ялангуяа, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, түүний эрх, үүрэг, хариуцлагыг хуульд нарийвчлан тусгаагүйгээс болж цаашид энэ байгууллагад улс

⁵ <http://nifs.gov.mn/?/page/14.jsp> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

⁶ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Д.Батжаргалын ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгаланд явуулсан албан бичигт тусгасан санал.

төрийн нөлөөлөл бий болох, улмаар шинжилгээний байгууллагын хараат бус байдалд сөрөг нөлөөлөл гарч болзошгүй. Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуульд шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, ажилтан албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгах шаардлагатай.

Түүнчлэн шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоотой холбоотой өөр нэгэн тулгамдсан асуудал бол шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байх тухай асуудал юм. Энэ талаар тус хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.” гэж тусгасан бөгөөд өнөөг хүртэл энэхүү хуульд тусгасан эрдэм шинжилгээ, судалгааны чиг үүрэг бүхий нэгжийг байгуулаагүй байна. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлж байгаагийн дотор санхүү, төсвийн хүндрэлтэй байдал, эрдэм шинжилгээ, судалгаа хийх техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу зэрэг нөлөөлж байгаа талаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн мэдээлэлд дурджээ. Мөн үүнээс гадна Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд үйл ажиллагаа явуулах Эрдмийн зөвлөлийг байгуулах эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгаагүй байна.⁷

Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуульд “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байна.” гэж тусгах, мөн “Шүүхийн шинжилгээний төв байгууллагын дэргэдэх эрдэм шинжилгээ, судалгааны нэгжид туслах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Эрдмийн зөвлөлийг шинжлэх ухааны салбар тус бүрээр мэргэшсэн, нарийн мэргэжлийн тэргүүлэх зэргийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн орон тооны бус гишүүдтэйгээр байгуулна” гэж тусгах саналтай байна.

2. Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тусгажээ. Энэ хүрээнд 2017 онд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нийтдээ 10,019.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэсэн байна.

Энэ байгууллагын нийт төсвийг авч үзвэл 70.2 хувийг цалин, нийгмийн даатгалын зардал, 2.4 хувийг байр ашиглалтын зардал, 7.8 хувийг урсгал шилжүүлэг, 19.6 хувийг бусад зардал эзэлж байна. Батлагдсан төсөвт эзлэх зардлын ангиллаар авч үзвэл 2013 онд цалин, нийгмийн даатгалын зардал 76 хувь, 2014, 2015 онд 85,5 хувь, 2016 онд 76,5 хувь, 2017 онд 70,2 хувь байна. Өнгөрсөн онуудад хөрөнгө оруулалт бараг хийгдээгүй ба 2015 онд 253,4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж авсан байна. Үүнээс үзэхэд нийт төсвийн ихэнх хувийг цалингийн зардал эзэлж байгаа

⁷ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс Хууль зүйн үндэсний хүрээлэнд 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр ирүүлсэн санал.

бөгөөд тоног төхөөрөмжийн шинэчлэл, хөрөнгө оруулалт хийгдээгүй нь үндсэн чиг үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болгоход хүргэж байна.⁸

Шүүхийн шинжилгээний байгууллагын төсөв, санхүүжилттэй холбоотой өөр нэгэн тулгамдсан асуудал бол шүүхийн шинжилгээний төв байрыг нүүлгэх эсэх асуудал юм. Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний байр Засгийн газрын ордноос 500 метр, ГХЯ-аас 300 метр, НЗДТГ-ын байрнаас 700 метр, МУИС, Боловсролын их сургууль, ШУТИС зэрэг нийслэлийн төр засаг, нийтийн үйлчилгээ төвлөрсөн хөл хөдөлгөөн ихтэй газар ойрхон зайтай байрладаг байна.⁹

Хотын төвийн А зэрэглэлийн байршилд байрлаж байгаа шүүх эмнэлэгт улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогч нар ирж үзүүлдэг, нас барсан тохиолдол болгонд задлан шинжилгээ хийгддэг. Тухайлбал, ДОХ, сүрьеэ, тарваган тахал гэх мэт халдварт өвчнөөр амиа алдсан иргэдийг авчирч шинжилгээнд оруулдаг. Магадгүй эндээс халдварт өвчин нийслэл хотод тархахыг үгүйсгэхгүй. Тиймээс шүүх эмнэлгийн задлан шинжилгээ болон цогцос хадгалах өрөө, зарим лабораторийг хотын захад шилжүүлэхэд анхаарах шаардлагатай.¹⁰

Мөн үүнээс гадна тулгарч байгаа өөр нэгэн асуудал бол зарим аймаг, орон нутгийн алба, хэсэг өөрийн байргүй байгаа явдал юм. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн мэдээллээр 2017 оны байдлаар 8 аймаг өөрийн байртай бөгөөд бусад алба, хэсэг түрээсийн болон цагдаагийн газар, хэлтэстэй хамт нэг байранд ажиллаж байна. Үүнээс үзэхэд нийт улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй алба, хэсгүүдийг өөрийн байртай болгоход анхаарал хандуулах шаардлагатай болох нь харагдаж байна.¹¹

Дээрхээс үзэхэд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа алба, хэсгүүдийг өөрийн байртай болгоход анхаарах, мөн Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний байрыг хотын зах уруу нүүлгэхэд анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шаардагдах төсөв батлагдахгүй байгаагаас шалтгаалж дараахь тулгамдсан асуудал гарч байна. Тухайлбал:

- Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг авч чадахгүйтэй холбоотой техник технологийн хоцрогдолд орж, зарим нэр төрлийн шинжилгээг хийж чадахгүй байх, эд мөрийн баримт үгүй болох, шинжилгээний дүгнэлт буруу гарах, албаны нууц задрах зэрэг эрсдэл гарч байна.

⁸ Шүүхийн шинжилгээний байгууллагын батлагдсан төсвийн товч танилцуулга, 2017 он.

⁹ Ч.Алтаншиг, “Шүүхийн шинжилгээний байгууллагын түүхэн хөгжил, хөгжлийн чиг хандлага, үйл ажиллагаанд тулгамдсан асуудал”, *Шүүхийн шинжилгээ эмхэтгэл*, Дугаар 4, (2017), 5 дахь тал.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Мөн тэнд.

- Албаны байр болон зориулалтын лаборатори байхгүйгээс болж албан хаагчдыг эрүүл мэнд хохирч байна. Мөн үүнээс гадна нормын хувцас, хөдөлмөр хамгаалал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгслийг хангаж чадахгүйгээс болж албан хаагчдын эрүүл мэнд эрсдэлд орж, халдварт өвчин авах эрсдэл үүсч байна.
- Авто машины шатахууны зардал хүрэлцдэггүй, жолоочийн орон тоо байдаггүй зэргээс шалтгаалж албаны шуурхай бэлэн байдал алдагдах нөхцөл бүрдсэн, мөн үүнтэй холбогдон шинжээч нарын ажлын ачаалал ихсэж байна.
- Дотоод албан томилолтын зардал дутуу батлагдсанаас болж албан хаагчид томилолтын хугацааны зардлаа бүрэн авч чадахгүй зохих хэсгийг хувиасаа гарган ажиллаж байна.
- Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг давтан мэргэшил дээшлүүлж, хөгжүүлж чадахгүй, мөн өндөр ур чадвартай, нарийн мэргэжлээр төгссөн албан хаагчдыг орчин үеийн техник багаж, хэрэгслээр хангаж чадахгүй байна.
- Орон тооны хүрэлцээгүй байдлаас болж албан хаагчид өндөр ачаалалтай ажиллаж байна.¹²

Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасан “Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоогчид анхаарах шаардлагатай.

3. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа

2017 оны байдлаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 210, Нийслэлийн шүүхийн шинжилгээний албанд 91, аймгийн шүүхийн шинжилгээний албанд 203, нийт 504 албан хаагч, ажилтнууд ажиллаж байна.¹³ Эдгээр ажилтан, албан хаагчдын хувьд ажлын ачаалал харилцан адилгүй байдаг байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.”, 43.2 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.”, 43.3 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.” гэж тусгасан. Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг хуульд зохих байдлаар тусгасан боловч байгууллагын ажилтан, албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, ажлын ачаалал өндөр байгаа зэрэг асуудал гарч байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Монгол Улсад үйлдэгдэж байгаа зарим төрлийн гэмт хэргийн тоо өссөн, мөн шинэ төрлийн гэмт


¹² Шүүхийн шинжилгээний байгууллагын батлагдсан төсвийн товч танилцуулга, 2017 он.

¹³ <http://nifs.gov.mn/?/page/14.jsp> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

хэргүүдийн арга хэлбэр нарийссан зэрэгтэй холбоотойгоор шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын ачаалал тогтмол өсөж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2017 онд 65525 шинжилгээ хийсэн байна. Нийт шинжилгээг чиглэлээр нь авч үзвэл 58,1 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 21,4 хувийг хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ, 20,1 хувийг криминалистикийн шинжилгээ, 0,3 хувийг эдийн засгийн шинжилгээ эзэлж байна.¹⁴ Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээний 58.1 хувийг шүүх эмнэлэг дангаараа хийж байгаа нь тус салбарын эмч, шинжээчдийн хэрэгцээ шаардлага нийгэмд их байгааг харуулж байна.

Зураг 1. Шинжилгээний чиглэл



Зураг 2. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт /сүүлийн 6 жилийн харьцуулалт/



¹⁴ Шүүхийн шинжилгээний статистик тайлан, 2017 он.

Дээрх зургаас үзэхэд сүүлийн жилүүдэд шүүхийн шинжилгээний байгууллагын нийт шинжилгээний тоо буураагүй болох нь харагдаж байна. Ингээд энэхүү байгууллагын ажилтан, албан хаагчдад тулгамдаж буй асуудлыг дэлгэрүүлэн авч үзье.

Шүүх эмнэлгийн шинжилгээний газар

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын дагуу Шүүх эмнэлгийн шинжилгээний газар нь дараахь чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:


- Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг хийж дүгнэлт гаргах;
- Цогцост задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Хүний биеийн эд эсэд гистологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Хавтаст хэргийн материалаар дүгнэлт гаргах;
- Эксгумаци (оршуулсан шарилд) шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Нэр хаяг тодорхойгүй, хариуцах эзэнгүй цогцос хадгалж, оршуулах;
- Шүүх эмнэлгийн чиглэлээр хийх шинжилгээ судалгааны ажилд дэмжлэг үзүүлж, зохион байгуулах;
- Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний ур чадварыг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхдээ 2017 оны байдлаар нийт 49 (дарга 1, дэд дарга 1, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, ахлах шинжээч 4, шинжээч эмч 21, гистологийн шинжээч 2, дүрс оношлогооны эмч 2, нарийн мэргэжлийн эмч 2, бага эмч 2, гистологийн лаборант 3, туслах ажилтан 8, угаагч 3) орон тоотой ажиллаж байна. Хөдөө орон нутгийн хувьд 21 аймгийн шүүхийн шинжилгээний албадад нийт 72 тооны шинжээч эмч, лаборант, туслах ажилтан ажиллаж байна.¹⁵


Мөн тус газрын ирүүлсэн мэдээллээр сүүлийн жилүүдэд Шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын ажлын ачаалал нэмэгдэж, хийгдэж байгаа шинжилгээний тоон үзүүлэлт өссөн байна. Тухайлбал, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын шинжилгээний тоон үзүүлэлтийг сүүлийн 8 жилээр харьцуулан харуулав.

¹⁵ Шүүх эмнэлгийн шинжилгээний газраас ирүүлсэн мэдээлэл.


Зураг 3. Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын шинжилгээний тоон үзүүлэлтийг сүүлийн 8 жилээр харьцуулсан байдал




Зураг 4. Цогцост хийгдсэн шинжилгээ



Зураг 5. Хүний биед хийгдсэн шинжилгээ



Зураг 6. Хэргийн материалаар хийгдсэн шинжилгээ



Дээрх статистик мэдээллээс үзэхэд 2009 оноос хойш жил ирэх тусам шинжилгээний тоон үзүүлэлт өссөн үзүүлэлттэй байгааг харж болно. Энэ нь нэгж

шинжээч эмчийн ажлын ачаалалтай харьцуулахад хүн амын суурьшил, нутаг дэвсгэрийн хэмжээ, зам харилцаа, гэмт хэргийн гаралт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байгааг харуулж байна. Мөн жилд дунджаар Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт цогцос шинжилгээ 80-85, хүний биед хийсэн шинжилгээ 600-650, хэргийн материалын шинжилгээ 100-120 хийдэг байна. Үүнээс үзэхэд Шүүх эмнэлгийн шинжээчийн ажлын ачаалал өндөр байгаа болох нь харагдаж байна.

Мөн үүнээс гадна Шүүх эмнэлгийн шинжээчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа өөр нэгэн хүчин зүйл бол шинжээч эмч нарын гаргасан дүгнэлтийг хохирогч, холбогдогч талын аль нэг нь хүлээн зөвшөөрөхгүй байх, прокурор эсхүл мөрдөн байцаагчийн санаачилгаар гэх мэт олон шалтгааны улмаас шинжээч эмчийн дүгнэлтийг дахин давтан бүрэлдэхүүнтэйгээр гаргах шаардлагатай болдог байна. Иймээс нэг талаас шинжээч эмч нарын ажлын ачааллыг харгалзах, нөгөө талаас бүрэлдэхүүнтэй хийгдэх шинжилгээний тоо, нөхцөл байдлыг харгалзан Шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын ажлын ачааллыг бууруулах талаар анхаарах шаардлагатай.

Эдийн засгийн шинжилгээний газар

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар”, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар баталсан “Эдийн засгийн шинжилгээ хийх журам”¹⁶-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Ингээд энэхүү газрын чиг үүргийг дор цухас авч үзье:

- Өмч хөрөнгө ашигласан, шамшигдуулсан хэрэг, төсөв зориулалтын бусаар зарцуулсан, өмч хөрөнгөтэй холбоотой албан тушаалын хэрэг, татвар төлөлттэй холбоотой хэрэг зөрчлийн холбогдолтой аудитын дүгнэлт гаргасан материалд шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Эдийн засгийн бусад хэрэг маргаанд шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Эд хөрөнгийн үнэлгээнд дүгнэлт өгөх;
- Орон тооны бус шинжээчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний мэдлэг, ур чадварыг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

¹⁶ Хууль зүй, дотоод хэргийн болон Сангийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/114, 141 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Эдийн засгийн шинжилгээ хийх журам”.

Эдийн засгийн шинжилгээний газар нь 2017 онд 231 шинжилгээ хийсэн байна.¹⁷ Харин орон нутгийн хувьд нийтдээ 136 шинжилгээ хийсэн байна. Ингээд орон нутагт хийсэн шинжилгээг 2009-2017 оны байдлаар товч хүргэе.

Хүснэгт 1. Эдийн засгийн шинжилгээний тоон мэдээлэл /2009-2017/

Он	Орон тоо	Гаргасан дүгнэлт		Шинжилгээ хийсэн объектын тоо	Орон тооны бус комисс ажиллаж байхад орон нутагт хийгдсэн шинжилгээ
		Нийт	Орон нутгаас		
2009	5	121	15	5982	20
2010	6	143	12	7893	31
2011	6	141	16	8415	25
2012	7	185	23	10958	21
2013	7	216	25	12317	18
2014	5	197	39	6425	-
2015	5	194	40	10246	-
2016	6	164	35	4533	-
2017	7	136	41	4926	-

Энэхүү тоон мэдээллээс үзэхэд Эдийн засгийн шинжилгээний газрын орон тоо болон хийж буй шинжилгээний объектын тоотой харьцуулахад ажлын ачаалал өндөр байгааг харуулж байна. Ингээд Эдийн засгийн шинжилгээний хэлтэст үүсч байгаа зарим тулгамдсан асуудлын талаар дор товч авч үзье.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 110/137 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Эдийн засгийн шинжилгээ хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт “Аймаг дахь орон тооны бус комиссын бүрэлдэхүүнийг Шүүхийн шинжилгээний албаны даргын саналыг үндэслэн Аймгийн засаг дарга 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж болно” гэж заасан байсан. Энэхүү журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А/114, 141 тоот хамтарсан тушаалаар хүчингүй болгосон.

¹⁷ Зөвхөн ШШҮХ-ийн Эдийн засгийн шинжилгээний хэлтэст хийсэн шинжилгээ. Аймгуудын орон тооны бус комиссын хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт ороогүй болно.

Үүнээс үүдэн 2017 оноос хойш хөдөө, орон нутагт хийгдэх эдийн засгийн шинжилгээг Улаанбаатар хотод хийх, эсхүл Улаанбаатар хотоос тухайн орон нутагт томилолтоор очиж шинжилгээг хийх болсон. Энэ нь эдийн засгийн шинжилгээний ажлын ачааллыг хоёр дахин нэмэгдүүлэхэд хүргэжээ. Үүнээс гадна орон нутагт хийгдэж байгаа шинжилгээ нь тухайн хугацаанаас хамаарч 14-30 хоногт хийгдэх шаардлагатай боловч томилолтын зардал хүрэлцээгүйгээс үүдэн эдийн засгийн шинжилгээ бүрэн хийгдэхгүй, улмаар чанаргүй хийгдэх тохиолдол гарч болзошгүй байдаг.¹⁸

Үүнээс үзэхэд Эдийн засгийн шинжилгээний ажлын ачаалалтай уялдуулан эдийн засгийн шинжээчдийн тоог нэмэгдүүлэх, мөн шүүхийн шинжилгээний орон нутгийн албадад эдийн засгийн шинжээч ажиллуулах талаар анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.

Тусгай шинжилгээний газар

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар” журмын дагуу Биологийн шинжилгээний лаборатори, ДНХ-ийн шинжилгээний лаборатори, Бактериологийн шинжилгээний лаборатори, Химийн шинжилгээний лаборатори, Физикийн шинжилгээний лаборатори гэсэн алба хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Ингээд энэ газар нь дараахь чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- Химийн бодис элементийн найрлага тогтоох, тодорхойлох шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Физикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Биологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- ДНХ-ийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Бактериологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Дуу авианы харьцуулсан шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- ДНХ-ийн шаардлагатай объектоор төрөлжсөн сан бүрдүүлж ашиглах шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Орон нутгийн шинжээчдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний мэдлэг, ур чадварыг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Ингээд эдгээр хэлтсүүдээс Химийн лаборатори ба биологийн лабораторид гарч байгаа тулгамдаж буй асуудлын талаар дор цухас авч үзье.

¹⁸ Эдийн засгийн шинжилгээний газраас ирүүлсэн мэдээлэл.

Тусгай шинжилгээний газрын биологийн лаборатори

Тус лабораторид өнөөгийн байдлаар 1 ахлах шинжээч, 2 шинжээч, 2 лаборант, 1 шил угаагчийн орон тоотой буюу нийт 7 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү лаборатори нь улсын хэмжээнд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэргийн эд мөрийн баримтад дүгнэлт гаргадаг байна. Ингээд энэхүү лабораторийн шинжилгээний тоог 2011-2017 оны байдлаар дор хүснэгтээр харуулав.¹⁹

Хүснэгт 2. Шинжилгээний тоо /2011-2017/

Он	Шинжилгээний тоо	Объектын тоо	Шинжээчийн тоо	Нэг шинжээчийн хийсэн шинжилгээний тоо /дунджаар/
2011	3137	12548	3	785
2012	4265	17060	3	1465
2013	5281	21124	4	1320
2014	5060	20240	4	1265
2015	5115	20460	4	1278
2016	5148	21780	3	1716
2017	5159	21980	3	1719

Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд 2011-2017 оны хооронд шинжилгээний объектын тоо болон нэг шинжээчид ногдож байгаа шинжилгээний тоо жил ирэх тусам өсөж, ажлын ачаалал нэмэгдэж байгааг харуулж байна. Үүнээс харахад тусгай шинжилгээний газрын биологийн лабораторийн шинжээчээр ажиллаж буй ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тусгай шинжилгээний газрын химийн лаборатори

Тусгай шинжилгээний газрын химийн лаборатори нь анх 2008 онд 6 орон тоотой үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл тус лабораторид ямар нэгэн орон тоо нэмэгдээгүй байна. Энэхүү лаборатори нь лабораторийн эрхлэгч 1, ахлах шинжээч

¹⁹ Тусгай шинжилгээний газрын биологийн лабораторийн ирүүлсэн мэдээлэл.

2, шинжээч 2, лаборант 1 гэсэн орон тооны бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Химийн лаборатори нь ажил үүргийн хувьд сэжигтэн, холбогдогч нараас болон хэргийн газраас хураагдсан эд мөрийн баримт, холбогдох бусад нотлох баримтад шинжилгээ хийдэг бөгөөд сүүлийн жилүүдэд шинжилгээний тоо өсөх хандлагатай байна. Ингээд сүүлийн 8 жилд хийсэн шинжилгээний тоог дор хүснэгтээр харуулъя.²⁰

Хүснэгт 3. Тусгай шинжилгээний газрын хийсэн шинжилгээний тоон мэдээлэл

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Шинжилгээний тоо	3740	5012	5194	4747	5529	5286	5348	4398

Энэхүү тоон мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд химийн шинжилгээний тоо өсөж байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд Тусгай шинжилгээний газрын химийн лабораторийг байгуулснаас хойш орон тоо нэмээгүй боловч химийн лабораторид хийгдэж байгаа шинжилгээний тоо өсөж байгаа нь харагдаж байна. Энэ нь лабораторийн ажлын ачааллыг харгалзан шинжээч ажилтны орон тоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай болохыг харуулж байна.

Ингээд судалгааны багийн зүгээс нэг талаас шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн эрх зүйн баталгааг хангахдаа шинжээч нарын ажлын ачаалалтай дүйцүүлэх хэмжээгээр цалин хөлс, олговрыг олгох, нөгөө талаас цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчтай уялдуулан эрх зүйн баталгааг хангах талаар хуульд нарийвчлан тусгах шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийж байна.

2.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн 4 дүгээр зүйл

Шүүхийн шинжилгээний зарчим

4.1. Шүүхийн шинжилгээ хийхэд дараахь зарчмыг баримтална:

4.1.3. хараат бус байх;

Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны хараат бус байдлыг хангах тухай зохицуулалтыг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт “шүүхийн шинжилгээ хийхэд хараат бус байх зарчмыг баримтална”, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэгт “шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл

²⁰ Тусгай шинжилгээний газрын химийн лабораторийн ирүүлсэн мэдээлэл.

ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно.” гэх зэргээр баталгаажуулж өгсөн. Энэ нь шинжээчийн шинжилгээ хийх явцад хараат бусаар ажиллахад чухал ач холбогдолтой болсон боловч практикт шинжээчийн хараат бус байдал зарим талаар хангагдахгүй байгаа талаар судалгааны үр дүн гарчээ.

Тухайлбал, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтнуудаас авсан социологийн судалгаагаар шинжээчид ихэвчлэн прокурор, мөрдөгч, мөн зарим талаараа дээд шатны удирдлагаас нөлөөлж болзошгүй байдал гардаг гэж хариулсан байна.²¹ Үүнээс үзэхэд шинжээчийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахдаа эдгээр субъектын эрх, үүрэг, хариуцлагыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай болох нь харагдаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоох шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно.”, 9.1 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт “Шинжээч гаргасан дүгнэлттэй холбоотой асуудлаар шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж мэдүүлэг өгнө.” гэж тусгажээ. Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч нар нь ихэнхдээ прокурор, мөрдөгчтэй илүү ойр ажилладаг болох нь харагдаж байна.

Түүнчлэн өнөөгийн хууль, эрх зүйн хүрээнд авч үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын үйл ажиллагааны хараат бус байдалд халдсан тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлага Шүүхийн шинжилгээний тухай хууль болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой бус байна. Үүнээс үүдэн шинжээчид хууль бусаар нөлөөлөх байдал гарч болзошгүй.

Иймээс Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 21.6.1 дэх хэсэгт “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ зүйлд шинжээчийг нэмж тусгах шаардлагатай. Иймээс Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 1-д Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчөөс гадна шинжээчийг нэмж тусгах саналтай байна.

²¹ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдаас авсан санал, асуулга, 2018 оны 2 дугаар сарын 21.

2.3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн 24 дүгээр зүйл. Криминалистикийн шинжилгээ
Хуулийн 25 дугаар зүйл. Шүүх эмнэлгийн шинжилгээ
Хуулийн 26 дугаар зүйл. Сэтгэцийн шинжилгээ
Хуулийн 27 дугаар зүйл. Эдийн засгийн шинжилгээ

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршино гэж тодорхойлжээ.

Шүүхийн шинжилгээ гэдэг нь тодорхой хэрэгт нотолбол зохих нөхцөл байдлыг тогтоох зорилгоор шүүх, шүүгч, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос шинжээчийн өмнө тавьсан бөгөөд шинжлэх ухаан, техник, урлагийн салбарын тусгай мэдлэг шаардагдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд шинжилгээ хийлгэх ба шинжээчийн дүгнэлт гарахаас бүрддэг байцаан шийтгэх ажиллагааны үйлдэл юм.²² Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээ хийх ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг чухал хэсэг болох нь харагдаж байна. Ингээд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд тусгасан зүйл, заалтын хэрэгжилтийг дор дэлгэрүүлэн авч үзье.

Криминалистикийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага нь Криминалистикийн шинжилгээг хийхдээ “эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад”²³ хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор энэ төрлийн шинжилгээг хийж байна. Тухайлбал, гарын мөр, мөр судлал, гар бичмэл, гарын үсэг, бичиг техник, дүр зураг, галт зэвсэг, тэсрэх төхөөрөмж, дуу болон дүрс бичлэгт шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж байна. Шинжилгээг хийхдээ ажиглалт, хэмжилт, туршилт, харьцуулалтын аргуудыг хэрэглэхээс гадна зориулалтын багаж, тоног төхөөрөмжийг ашиглах бөгөөд сүүлийн 9 жилийн хугацаанд нийт 84042²⁴ шинжилгээг хийсэн байна.

²² С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг* (УБ, 2013), Адмон хэвлэл, 631 дэх тал.

²³ Криминалистикийн шинжилгээ хийх журам, 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

²⁴ *Шүүхийн шинжилгээний статистик-2013*, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, (УБ, 2014), ШШҮХ, 6 дахь тал., *Шүүхийн шинжилгээний статистик-2017*, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, (УБ, 2018), ШШҮХ, 4 дэх тал.

Үүнээс гадна шүүхийн шинжилгээний байгууллагаас ирүүлсэн танилцуулга, мэдээлэлд дурдсанаар зарим тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, сум, галт хэрэгсэл, цацраг идэвхт үүсгүүр, хими, биологийн болон аюул учруулж болзошгүй бусад объектод шинжилгээ хийж байгаа боловч тоног төхөөрөмж, шинжилгээний лабораторийн хүрэлцээ муу, мөн тусгай мэдлэг бүхий шинжээчийн дутмаг байдлаас шинжилгээ хийх боломжгүйд хүрэх тохиолдол гарсаар байна. Түүнчлэн шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зүгээс шинжилгээний объектыг хүргүүлэхдээ тээвэрлэлтийн шаардлагыг хангахгүй илгээсний улмаас тухайн объектын шинж чанар, хэлбэр дүрст өөрчлөлт орж шинжилгээний дүгнэлтэд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс үүдэн хэргийн оролцогчид тухайн шинжилгээний хариуг хүлээн зөвшөөрөхгүй, шинжилгээг дахин хийлгэж байгаа нь ачааллыг нэмэгдүүлж, улмаар шүүхийн шинжилгээний байгууллагын төсвөөс үргүй зардал гарсаар байна. Иймээс криминалистикийн шинжилгээ хийхтэй холбоотой дээр дурдсан асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай.

Шүүх эмнэлгийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хууль, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм, Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам болон бусад холбогдох журамд заасны дагуу “эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан анагаах ухаан, биологийн холбогдолтой асуудлаар”²⁵ хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор энэ төрлийн шинжилгээг хийж байна. Тухайлбал, цогцост шинжилгээ хийх, гэмтлийн зэрэг тогтоох, шарилд шинжилгээ хийх, гистологийн зэрэг шинжилгээг хийж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь 2017 онд нийт 65525 шинжилгээ хийснээс 38090 шинжилгээг шүүх эмнэлгийн чиглэлээр хийсэн бөгөөд энэ нь нийт шинжилгээний 58.1 хувийг эзэлж байна. Түүнчлэн сүүлийн 4 жилийн хугацаанд энэ төрлийн шинжилгээний нийт тоо өссөн үзүүлэлттэй байгаагаас ажлын ачаалал их байгаа нь харагдаж байгаа юм.²⁶ Үүнээс үүдэн хувийн эмнэлгүүд тодорхой хэмжээнд үзлэг, шинжилгээг хийж байгаа нь сайшаалтай боловч нөгөө талаас эдгээр эмнэлгийн үзлэг, шинжилгээ, лабораторийн хариу нь хоорондоо харилцан адилгүй гардаг байна. Мөн үзлэг, шинжилгээний хариу нь хоорондоо ялгаатай, эргэлзээ төрүүлэхүйц байгаа нь тэдгээрт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар, ажилласан жилийн туршлага зэрэг нь харилцан адилгүй байгаагаас ихээхэн хамаарч байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газар нь бүх төрлийн нарийвчилсан шинжилгээг хийдэг учраас тус газарт ажиллаж буй

²⁵ Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам, 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

²⁶ Шүүхийн шинжилгээний статистик-2017, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, (УБ, 2018), ШШҮХ, 4-5 дахь тал.

эмч болон нарийн мэргэжлийн эмч, лаборант зэрэг ажилчдын орон тоог нэмээд зогсохгүй тэднийг ажиллах нөхцөлөөр хангаж, мэдлэг, мэргэшил болон ур чадварыг нь тогтмол сайжруулж байх хэрэгцээ шаардлага эн тэргүүнд тавигдаж байгааг анхаарах хэрэгтэй.

Сэтгэцийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага нь сэтгэцийн шинжилгээг тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор энэ төрлийн шинжилгээг хийж байна. Тухайлбал, эрүүгийн хэргийн хувьд гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тодорхойлох шинжилгээ хийнэ. Иргэний болон захиргааны хэргийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч, эсхүл хариуцагч нь иргэний эрх зүйн чадамжтай эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тодорхойлох шинжилгээ хийнэ. Шинжээчийн хувьд сэтгэцийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа сэтгэцийн үзлэг, шинжилгээнээс гадна урьд нь тухайн этгээдийн эмчлүүлж, шинжлүүлж байсан эмнэлгийн баримт бичгийг харгалзан энэ төрлийн шинжилгээг хийж байна.

Эдийн засгийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага нь Эдийн засгийн шинжилгээ хийх журамд заасны дагуу “эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад”²⁷ хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор энэ төрлийн шинжилгээг хийж байна. Тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баримтын шалгалтаар тогтоосон эд хөрөнгийн дутагдал, илүүдэл нь хэргийн бодит байдалтай тохирохгүй байгаа, баримтын шалгалт хийсэн улсын байцаагч эд хөрөнгийн дутагдал, илүүдлийн хэмжээг үнэн зөв, бодитой тодорхойлж чадаагүй нь мөрдөн шалгах ажиллагааны явцад илэрсэн зэрэг тохиолдолд эдийн засгийн шинжилгээг хийж байна. Сүүлийн 9 жилийн хугацаанд нийт 1591²⁸ шинжилгээг хийжээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь дээр дурдсан нэр төрлийн шинжилгээг хийж байгаа боловч тус хүрээлэнгийн газар, хэлтэс, нэгжүүдээс ирүүлсэн танилцуулга мэдээлэлд дурдсанаар нийгэм, эдийн засгийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, төвлөрөл зэргээс хамааран сүүлийн үед гарч буй гэмт хэрэгт байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн гэх зэрэг шинэ төрлийн шинжилгээг хийх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

²⁷ Эдийн засгийн шинжилгээ хийх журам, 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

²⁸ Шүүхийн шинжилгээний статистик-2013, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, (УБ, 2014), ШШҮХ, 6 дахь тал., Шүүхийн шинжилгээний статистик-2017, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, (УБ, 2018), ШШҮХ, 5 дахь тал.

Тухайлбал, Нийслэлийн прокурорын газраас шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхийг сайжруулах талаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2017 онд хүргүүлсэн албан бичигтээ сүүлийн үед үйлдэгдэж байгаа гэмт хэргийн арга, хэлбэр нарийсаж өндөр зохион байгуулалтанд орж байгаа бөгөөд эдийн засгийн, хүрээлэн байгаа орчны эсрэг, соёлын өвийн эсрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг зэрэг гэмт хэргийн гаралт жил ирэх тусам нэмэгдэж байгаатай холбогдуулан эдгээр гэмт хэргийг хянан шийдвэрлэх, хэргийн бодит байдлыг тогтооход тусгай мэдлэг бүхий шинжээчээр дүгнэлт гаргуулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Гэвч дээрх чиг үүргийг хэрэгжүүлдэг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шинжээчийн дүгнэлт гаргуулахаар “... Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг баримтлан дүгнэлт гаргах боломжгүй ...” хэмээн буцаадаг. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.8 дугаар зүйлийн 27.8.2 дахь хэсэгт заасны дагуу шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй тохиолдолд дахин шинжилгээ хийлгэхээр бүрэлдэхүүнтэй шинжээч нарыг томилоход “... тухайн чиглэлээр дүгнэлт гаргах өөр мэргэшсэн шинжээч байхгүй ...” гэх шалтгаанаар дүгнэлт гаргахаас татгалздаг байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ихээхэн хүндрэл бэрхшээл учруулж байгаа тул дээрх нөхцөл байдлыг судлан үзэж, Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шүүхийн шинжилгээний байгууллагыг олон улсын жишигт нийцсэн, сүүлийн үеийн техник хэрэгслээр хангах, боловсон хүчний чадавхи, орон тоог сайжруулах замаар үйл ажиллагааг нь хэвийн явуулах тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг хүсчээ.

Дээрхээс үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох шүүхийн шинжилгээнд дээр дурдсан шинэ төрлийн шинжилгээг хийж, дүгнэлт гаргах тусгай мэдлэг бүхий шинжээч дутмаг, зарим тохиолдолд тухайн шинжилгээг хийх шинжээч байхгүй зэрэг бэрхшээлтэй асуудал гарсаар байгаа нь үүнээс харагдаж байна.

Үүнээс гадна Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын хуралдаанаас Зөрчлийн тухай хуульд заасан байгаль орчныг хамгаалах журмын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог эргэн харж, шаардлагатай тохиолдолд Эрүүгийн хуульд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд байгаль орчинд учруулсан экологийн хохирлын үнэлгээг тогтоох үүрэг бүхий нэгжийг яаралтай байгуулах зэрэг ажлыг 2018 онд шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд үүрэг болгосон шийдвэр гарсан байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн улмаас байгаль экологи, хүрээлэн буй орчинд их хэмжээний хор хохирол учрахаас гадна энэ төрлийн гэмт хэрэг нь иргэдийн Үндсэн хуулиар олгосон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь шууд байдлаар зөрчиж байдаг. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 14 жилийн хугацаанд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг нийт 2632, жилд дунджаар 188 бүртгэгдсэн

бол 2016 онд 165 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Үүнээс 2 нь хүнд, 9 нь хөнгөн төрлийн гэмт хэрэг байгаа бол үлдсэн 154 гэмт хэрэг нь хүндэвтэр төрлийн гэмт хэрэг байна. Мөн энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бүс нутгаар нь ангилан авч үзвэл нийт гэмт хэргийн 86.7% нь орон нутагт, үүнээс 13.3% нь баруун, 21.8% нь хангайн, 45.5% нь төвийн, 10.3% нь зүүн бус нутагт үйлдэгдсэн байна. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн улмаас 2016 онд 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирснаас нийт хохирлын 55.1%-ийг буюу 2.7 тэрбум төгрөгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.²⁹

Дээрх тоо баримт, статистик мэдээллээс үзэхэд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг нь орон нутагт ихээр гарч байгаа төдийгүй энэ төрлийн гэмт хэргийн улмаас бий болсон хохирлыг бүрэн дүүрэн барагдуулж чадаагүй нь байгаль орчинд учирсан хохирлын хэмжээг тодорхойлох нэгдсэн арга, аргачлал тогтоогүй байгаатай холбоотой байхыг үгүйсгэхгүй юм. Нөгөө талаас газар, түүний хэвлий, хөрс, усны бохирдлын хэмжээг тогтоож эдийн засгийн үнэлгээ хийх, ашигт малтмалыг олборлох, боловсруулах явцад үүсэх экологийн хохирлыг тогтоож эдийн засгийн үнэлгээ хийх чадвартай тусгай мэдлэг бүхий шинжээч байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, зарим тохиолдолд үүссэн бодит хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүйд хүрч байна. Иймд энэ төрлийн гэмт хэрэгт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай мэдлэг бүхий шинжээчдийг бэлтгэх хэрэгцээ шаардлага эн тэргүүнд тавигдаж байгаа нь харагдаж байна.

Шинэ төрлийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хэрэгцээ шаардлага тулгарч байгаа дараагийн анхаарах асуудал бол цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг юм. Сүүлийн жилүүдэд цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо ихээр өсөж байгаа төдийгүй үүнийг дагаад цахим гэмт хэргийн төрөл, хэлбэр ч мөн нэмэгдэж байна. Тухайлбал, цахим орчинд бусдыг доромжлох, гүтгэх, бусдын захидал харилцааны нууцад халдах, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих зэрэг гэмт хэргийн гаралт ихсэж байна. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь ихэнх тохиолдолд хувь хүний нууцад хамаарах мэдээ мэдээлэлд халдаж байдгаараа хор хохирол ихтэйд тооцогддог юм.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг 47 бүртгэгдсэн бол үүний 38 гэмт хэрэг нь 2014-2017 онд гарсан байна. Энэ нь 4-5 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм. Мөн 2014 оноос 2017 оны эхний сарын байдлаар цахим орчинд гэмт хэргийн хохирогч болсон тухай нийт 476 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 202 гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна. Тус 202 эрүүгийн хэргийн 16 нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шатанд явж байгаа бол 39 хэрэгт яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт санал хүргүүлж, 29 хэргийг яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлж, 20 хэргийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 98 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.³⁰

²⁹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016, УБ., 2017 он, 237-239 дахь тал.

³⁰ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016, УБ., 2017 он, 228-229 дэх тал.

Дээрх тоо баримт, статистик мэдээллээс үзэхэд нийт хэргийн 46.5%-ийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь ноцтой үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, шалгах, хянан шийдвэрлэх цогц тогтолцоо, арга тактик, туршлага манай улсад дутагдаж байгаа нь харагдаж байна. Түүнчлэн цахим өгөгдлийг нотлох баримтад тооцдоггүй зэрэг байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж, хэргийн явцыг удаашруулж байгааг үгүйсгэх аргагүй юм. Үүнээс гадна өөр нэгэн хүчин зүйл нь цахим орчинд үйлдэгдсэн болон цахим төхөөрөмж ашиглаж үйлдсэн гэмт хэргийн дүнд гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан сиди, флаш, зөөврийн хатуу диск, тэдгээрт бэхжүүлж авсан дуу, дүрсний бичлэгт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай мэдлэг бүхий шинжээч хомс, техник хэрэгслийн дутмаг зэрэг байдал энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд нөлөөлж байгаа нь тодорхой харагдаж байна.

Үүнээс дүгнэн үзвэл Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд тусгасан зарим төрлийн шинжилгээний онцлог төрлүүдийг хийхэд нэг талаас шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, мөн одоо ажиллаж буй шинжээчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах. Нөгөө талаас эдгээр төрлийн шинжилгээг хийхэд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад анхаарах шаардлагатай. Түүнчлэн эдгээр шинжилгээний төрлөөс гадна шинэ төрлийн шинжилгээний төрлүүд болох дээр дурдсан байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн гэх зэрэг шинжилгээний төрлийг Шүүхийн шинжилгээний тухай хуульд нарийвчлан тусгах шаардлагатай гэсэн саналыг хүргүүлж байна.

2.4. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн 11 дүгээр зүйл. Шинжилгээ хийх хугацаа

11.1. Шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг шүүхийн шинжилгээний байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн шинжилгээ хийж дуусгах хугацааг тооцно.

11.2. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно.

11.3. Шинжээч нь энэ хуулийн 11.2-т заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол шинжилгээ хийх хугацааг сунгуулах тухай хүсэлтээ шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргана.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан хүсэлтийг хүлээн авсан этгээд шүүхийн шинжилгээ хийх хугацааг мөн хуулийн 11.2-т заасныг үндэслэн сунгана.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шинжилгээг хийж, дүгнэлт гаргана. Мөн криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц, эдийн засаг болон тусгай төрлийн

шинжилгээг хуульд заасны дагуу шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болох мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх болон төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд хийж, дүгнэлт гаргаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоох шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно”, мөн зүйлийн 9.1.3 дахь хэсэгт “Шинжээч томилох шийдвэрт шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжилгээний байгууллагын болон шинжээчийн нэр, шинжээчид тавих асуулт, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацаа, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн эд мөрийн баримтын талаархи мэдээллийг тусгана” гэж заасан байна.

Түүнчлэн мөн хуулийн 27.1 дүгээр зүйлийн 27.1.3 дахь хэсэгт “Шинжээч томилох шийдвэрт шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжилгээний байгууллага, шинжээчийн нэр, шинжээчид тавих асуулт, шинжилгээ хийх хугацаа, шинжилгээний объектын талаархи мэдээллийг тусгана”, мөн зүйлийн 27.1.7 дахь хэсэгт “Шинжээч нь шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрт тогтоосон хугацаанд шинжилгээ хийж, дүгнэлт гаргана” гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь эрүү, иргэн болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулах зорилгоор криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц, эдийн засаг болон тусгай төрлийн шинжилгээг хийлгэхээр шинжээч томилж байна. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжээч томилох шийдвэртээ шинжилгээг хийж, дүгнэлт гаргах хугацааг зааж өгөх ба шийдвэрийг хүлээн авсан тухайн шинжээч нь эрх бүхий этгээдийн тогтоосон хугацаанд шинжилгээг хийж, дүгнэлт гаргах үүрэгтэй болох нь харагдаж байна.

Үүнээс гадна Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно” гэж заажээ. Үүнээс үзэхэд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээний хугацааг тогтоохдоо тухайн шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог, цар хүрээ, объектын тоо хэмжээ зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр шинжилгээний хугацааг ялгамжтай байдлаар тогтоож байхыг заажээ.

Түүнчлэн “Криминалистикийн шинжилгээ хийх журам”³¹-ын 7 дугаар зүйлд дүгнэлт гаргах хугацааг зохицуулж өгсөн бөгөөд 7.1 дэх хэсэгт заасанчлан криминалистикийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацааг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасныг баримтлан тогтоохоор байна.

³¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 119 тоот тушаалаар батлагдсан “Криминалистикийн шинжилгээ хийх журам”.

“Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм”³²-ийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх хэсэгт заасанчлан сэтгэцийн болон тусгай төрлийн шинжилгээг эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрт заасан хугацаанд хийж, дүгнэлтийг гаргахаар байна.

“Эдийн засгийн шинжилгээ хийх журам”³³-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацааг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу тогтоохоор тус тус зохицуулжээ.

Дээрх журамд заасан зохицуулалтаас үзэхэд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор тусгай мэдлэг бүхий шинжээчээр криминалистик, сэтгэц, эдийн засаг болон тусгай төрлийн шинжилгээг хийлгэхдээ Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу хугацааг тогтоохоор байна.

Харин “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”³⁴-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Шинжээч нь зөвхөн эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамжаар шинжилгээ хийж дүгнэлт гаргана” гэж заажээ. Гэсэн хэдий боловч мөн журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар нэг талаас шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжээчийн дүгнэлт гаргах хугацааг тогтоохдоо шинжилгээний шинжлэгдэхүүний төрөл, онцлог, цар хүрээг харгалзан үзэх шаардлагатай байна. Нөгөө талаас мөн зүйлийн 6.2 дахь хэсэгт зааснаар тухайн шинжээч шинжилгээ хийлгэх тогтоол хүлээн авсанаас хойш дор дурдсан хугацаанд дүгнэлтийг гаргах чиглэлийг баримтлахаар тусгажээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 4. Шүүх эмнэлгийн шинжилгээний хугацаа

Шинжилгээний төрөл	Хугацаа /хоног/
Хүний биед үзлэг хийх	ажлын 3 хүртэл
Нэмэлт шинжилгээ хийх	ажлын 5 хүртэл
Цогцос шинжлэх	ажлын 10 хүртэл
Эд эсийн болон нэмэлт шинжилгээ хийх, эсхүл хэргийн материалд шинжилгээ хийх	ажлын 21 хүртэл

³² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 82 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм”.

³³ Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/114, 141 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Эдийн засгийн шинжилгээ хийх журам”.

³⁴ Хууль зүйн сайд болон Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/215, 421 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”.

Лабораторийн нарийн шинжилгээ хийх	ажлын 21 хүртэл
Шарил шинжлэх	ажлын 21 хүртэл

Дээрх хүснэгтэнд үзүүлсэнчлэн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацаа нь шинжилгээ тус бүрийн хувьд ялгамжтай байгаагаас харахад тухайн шинжилгээг түүний төрөл, онцлог, цар хүрээ зэрэг нөхцөл байдлаас хамааран тусгай арга, аргачлалын дагуу хийж, дүгнэлт гаргах шаардлагатай байдаг нь тодорхой харагдаж байгаа юм.

Эдгээр зохицуулалтын хүрээнд практикт шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болох мөрдөгч, прокурор, шүүгч зэрэг нь шинжилгээ хийлгэхээр шинжээч томилж буй шийдвэртээ дээр дурдсан бүх төрлийн шинжилгээг хийж, дүгнэлт гаргах хугацааг “3-5 хоногийн хугацаатайгаар”³⁵ тогтоож байна. Шинжилгээг тусгайлан тогтоосон арга, аргачлалын дагуу хийхэд 3-5 хоногийн хугацаа хангалтгүй байдаг. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд уг шийдвэрийг гаргахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1.1, 9.1.3, 27.1.3 болон 27.1.7 дахь хэсгийг үндэслэл болгож байгаа юм. Өөрөөр хэлбэл шинжээч томилох шийдвэрээ гаргахдаа шинжлэх магадлах салбарын нарийвчилсан зохицуулалт болох Шүүхийн шинжилгээний шинжилгээний тухай хууль, тэр дундаа хуулийн 11.2 дахь хэсэг болон дээр дурдсан журмыг харгалзан үзэхгүй байгаа нь тодорхой харагдаж байна.

Энэ талаар зарим судлаач “Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11.2-т “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно” гэж заасан. Энэ заалт амьдралд хэрэгжихэд төвөгтэй байгаа нь анзаарагддаг. Учир нь шинжээч томилж буй албан тушаалтан тухайн шинжилгээний цар хэмжээ, онцлогийн талаар мэдлэг муутай, нөгөө талаар шинжээчдийн ажлын ачаалалтай холбоотойгоор хууль зөрчигдөх байдал харагдаж байна”³⁶ гэжээ.

Үүнээс дүгнэхэд нэг талаас шинжилгээ хийлгэхээр шинжээч томилж буй эрх бүхий этгээд нь тухайн шинжилгээний төрөл, онцлог, цар хүрээ болон шинжилгээнд ирүүлж буй объектын тоо хэмжээ, чанар зэргийн талаар нарийн мэдлэг, мэдээлэл байхгүйн улмаас эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэлгүйгээр бодит байдалд нийцтэй бус, шинжилгээ хийн дүгнэлт гаргаж амжихааргүй хугацааг тогтоож байна. Нөгөө талаас мөрдөгч, прокурор, шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тал гэдэг утгаар зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан шинжилгээний хугацааг тогтоож байна.

³⁵ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн танилцуулга мэдээлэл.

³⁶ Т.Очирбат, “Шүүхийн шинжилгээний байгууллага болон хууль сахиулах бусад байгууллагуудын ажлын уялдаа, эрх зүйн зохицуулалт, хүний нөөц, техник, технологийн асуудал”, *Гэмт явдалтай тэмцэх асуудал* №2-60 (2017): 91-92 дахь тал.

Шинжилгээг хийж, дүгнэлт гаргахдаа тухайн шинжилгээний төрөл, онцлог, цар хүрээ зэргийг харгалзан үзэхээс гадна тухайн шинжилгээг тусгайлан тогтоосон арга, аргачлалаар мөн холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу хийж гүйцэтгэснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт хангагдах юм. Түүнчлэн шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх нэг чухал хүчин зүйл нь шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацааны асуудал юм. Гэсэн хэдий боловч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зүгээс шинжилгээний хугацааг тогтоохдоо Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасныг харгалзан үзэхгүй байгаа нь хууль зөрчигдөхөд, цаашилбал шинжилгээний хариу бодитой бус, сөрөг гарахад нөлөөлж байна.

Мөрдөгч, прокурор, шүүгчийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацааг тогтоож байгаагаас практикт гарч буй асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхой хэмжээнд шийдвэрлэх зорилгоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтсээс Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, цагдаа, хууль хяналтын байгууллагуудад шинжилгээний жишиг хугацаа, бичиг баримтын шинжилгээнд бичгийн загвар авах зөвлөмж гарган хүргүүлсэн байдаг.³⁷ Гэсэн хэдий ч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зүгээс шинжилгээний хугацааг тогтоохдоо уг жишиг хугацааг баримтлахгүй байгаа нь ач холбогдолгүй зүйл хэвээр байсаар байна.

Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болох мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх болон хуульд заасан төрийн эрх бүхий байгууллагын зүгээс бүх төрлийн шинжилгээний хугацааг 3-5 хоногийн хугацаатайгаар тогтоож байгаа нь нэг талаас эдгээр субъектэд шинжилгээний хугацааг тогтоох давуу эрхийг хуулиар олгосонтой холбоотой бол нөгөө талаас шинжилгээний хугацааг тогтоохдоо шинжилгээ хийж, дүгнэлт гаргах боломжтой жишиг хугацааг харгалзан үзэх, эсхүл тухайн мэргэжлийн байгууллага, түүний удирдлагаас санал болгож буй зөвлөмжийг зайлшгүй харгалзан үзэх талаар Шүүхийн шинжилгээний тухай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаатай холбоотой юм.

Иймд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацаатай холбогдон практикт гарч буй эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд шинжилгээ хийх хугацааг тухайн шинжилгээний төрөл, онцлогоос хамааран хуулиар тусгайлан зохицуулж өгөх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл шүүхийн шинжилгээний байгууллагаас тогтоосон бүх төрлийн шинжилгээний жишиг хугацааг хуульд нарийвчлан тусгаж өгөх, эсхүл эдгээр хугацааг Засгийн газрын тогтоолоор нарийвчлан зохицуулах боломж байгааг дурдмаар байна.

³⁷ Шүүхийн шинжилгээний байгууллагын 2014, 2015, 2016, 2017 оны үйл ажиллагааны тайлангаас.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Шүүхийн шинжилгээний тухай хууль 2009 онд батлагдсанаас хойш 9 жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн талаар хэд хэдэн судалгаа хийгдэж байсан бөгөөд энэ хууль батлагдсанаар шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоо бий болоход чухал ач холбогдолтой болсон боловч практикт зарим тулгамдсан асуудал гарсаар байна.

Тухайлбал, энэ хуульд шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, түүний бүрэн эрх тодорхой бус, шүүхийн шинжилгээний байгууллагын төсөв, санхүүжилт хангалтгүй, шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эдийн засаг, нийгэм, хууль зүйн, баталгааг нарийвчлан тусгаагүй зэрэг асуудал гарч байна.

Үүнээс гадна шүүхийн шинжилгээний хугацаа тодорхой бус, зарим тусгай мэдлэг шаардагдах шинжилгээг хэрхэн хийх талаарх зохицуулалт хуульд тодорхой бус, шүүхийн шинжилгээний ажилтан, албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, мөн шинжээчийн хараат бус байдлыг хангах зэрэг шаардлагатай зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах шаардлага гарч байна. Ингээд уг үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу дараахь саналыг дэвшүүлж байна.

1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37, 39, 43 дугаар зүйлд тусгасан асуудлыг “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ. Үнэлгээний багийн зүгээс шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, санхүүжилт, шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг тусгасан зүйл, заалтууд нь энэ хуулийн 1 дүгээр зүйлд тусгасан уг хуулийн зорилттой зарим талаар нийцээгүй байна гэж үнэллээ. Ингээд зүйл, заалт тус бүрээр санал, зөвлөмжийг товч хүргэе.

Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоог тодорхойлсон боловч шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон нарийвчилсан зохицуулалт уг хуульд дутмаг байгаа нь харагдаж байна. Үүнээс үүдэн шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, түүний эрх, үүрэг тодорхойгүй, шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн эрх зүйн байдал тодорхой бус байна.

Мөн үүнээс гадна энэ хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны

нэгжтэй байж болно” гэж заасан боловч энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй буюу өнөөг хүртэл Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд эрдэм шинжилгээ, судалгааны төвийг байгуулаагүй байна.

Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуульд шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, ажилтан албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгах шаардлагатай. Мөн Шүүхийн шинжилгээний тухай хуульд “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байна.” гэж энэ хуульд тусгах, мөн “Шүүхийн шинжилгээний төв байгууллагын дэргэдэх эрдэм шинжилгээ, судалгааны нэгжид туслах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Эрдмийн зөвлөлийг шинжлэх ухааны салбар тус бүрээр мэргэшсэн, нарийн мэргэжлийн тэргүүлэх зэргийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн орон тооны бус гишүүдтэйгээр байгуулна” гэж тусгах саналыг дэвшүүлж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж тусгасан боловч практикт энэ заалтын хэрэгжилт сул байна. Үүнээс үүдэн Шүүхийн шинжилгээний байгууллагын батлагдсан нийт төсвийн ихэнх хувийг цалингийн зардал эзэлж байна. Үүнээс үүдэн энэ байгууллагад тоног төхөөрөмжийн шинэчлэл, хөрөнгө оруулалт хийгдээгүй нь үндсэн чиг үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болгож байна.

Үүнээс гадна Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний байр хотын төвд байрлаж байгаа нь нийслэл хотод халдварт өвчин тархах эрсдэлтэй байна. Иймээс энэ асуудалд анхаарлаа хандуулж Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний байрыг хотын захаас нүүлгэн шилжүүлэх, мөн шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн ажлын ачааллыг бууруулах талаар анхаарах шаардлагатай.

Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлд шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн эрх зүйн баталгааг тусгасан боловч энэ байгууллагын ажилтны ажиллах орчин нөхцөл, мөн ажлын ачаалал өндөр байгаа зэрэг тулгамдсан асуудал гарч байна.

Иймээс Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн ажлын ачаалалтай дүйцүүлэн цалин хөлс, нийгмийн баталгааг олгох, мөн энэ байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчтай адил хангах талаар судалж, эрх зүйн баталгааг хангах шаардлагатай.

2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт “шүүхийн шинжилгээ хийхэд хараат бус байх зарчмыг баримтална” гэж тусгасан. Энэхүү заалтыг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж, үнэлгээг гүйцэтгэлээ. Үнэлгээгээр шинжээчид ихэвчлэн прокурор, мөрдөгч, мөн дээд шатны албан тушаалтан нөлөөлж болзошгүй байдаг гэж судалгаанд оролцогч нар хариулсан байна.³⁸

Иймээс Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 21.6.1 дэх хэсэгт “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ зүйлд шинжээчийг нэмж тусгах шаардлагатай гэсэн саналыг хүргүүлж байна.

3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд “криминалистик, шүүх эмнэлэг, сэтгэц болон эдийн засгийн шинжилгээний онцлог”-ийг тусгасан. Эдгээр төрлийн шинжилгээний онцлогийг “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ. Үнэлгээгээр криминалистик, шүүх эмнэлгийн, сэтгэцийн, эдийн засгийн гэх зэрэг шинжилгээг хийхэд зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмж шаардагддаг, мөн үүнтэй холбоотой шинжээчийн мэдлэг, ур чадвар, хүний нөөцийг сайжруулах шаардлагатай гэсэн саналууд иржээ.³⁹

Түүнчлэн сүүлийн үед эдгээр төрлийн шинжилгээнээс гадна шинэ төрлийн шинжилгээ болох байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн зэрэг шинжилгээг хийх хэрэгцээ шаардлага тулгарч байна гэж судалгаанд оролцогч нар хариулсан байна.⁴⁰

³⁸ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдаас авсан санал, асуулга, 2018 оны 2 дугаар сарын 21.

³⁹ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдаас авсан санал, асуулга, 2018 оны 2 дугаар сарын 21.

⁴⁰ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдаас авсан санал, асуулга, 2018 оны 2 дугаар сарын 21.

Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 24-27 дугаар зүйлд тусгасан зарим төрлийн шинжилгээний онцлог төрлүүдийг хийхэд нэг талаас шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, мөн одоо ажиллаж буй шинжээчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах. Нөгөө талаас эдгээр төрлийн шинжилгээг хийхэд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад анхаарах шаардлагатай.

Түүнчлэн эдгээр шинжилгээний төрлөөс гадна шинэ төрлийн шинжилгээний төрлүүд болох дээр дурдсан байгаль экологийн, цахим төхөөрөмжийн, инженер техникийн гэх зэрэг шинжилгээний төрлийг Шүүхийн шинжилгээний тухай хуульд нарийвчлан тусгах шаардлагатай гэсэн саналыг хүргүүлж байна.

4. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд “шинжилгээ хийх хугацаа”-нд холбогдох зохицуулалтыг тусгасан. Энэхүү зүйлийг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж, үнэлгээг гүйцэтгэлээ. Үнэлгээгээр шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоож байгаа хугацаа нь шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад хангалттай байж чаддаггүй гэж судалгаанд оролцогч нар хариулсан байна.⁴¹ Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно.” гэсэн зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж, тухайн чиглэлийн шинжилгээний хугацааг түүний онцлогоос хамааран ялгаатай байдлаар хуульд тусгах шаардлагатай. Эсхүл Засгийн газрын тогтоолоор тухайн чиглэлийн шинжилгээний төрөл нэг бүрийн жишиг хугацааг тогтоож болох эсэх талаар судлах шаардлагатай гэсэн саналыг гаргаж байна.

⁴¹ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдаас авсан санал, асуулга, 2018 оны 2 дугаар сарын 21.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, дүрэм журам

Цагдаагийн албаны тухай хууль /2017 он/
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/
Шүүхийн шинжилгээний тухай хууль /2009 он/
Эрүүгийн хууль /2015 он/
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2015 он/

Криминалистикийн шинжилгээ хийх журам /2010 он/
Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам /2017 он/
Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам /2014 он/
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм /2011 он/
Шүүхийн шинжилгээ хийх ажиллагаанд тавих шаардлага, байгууллагын стандарт /2013 он/
Эдийн засгийн шинжилгээ хийх журам /2017 он/

Ном, гарын авлага, өгүүлэл, нийтлэл

Б.Мөнхдорж нар, *Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016*, Мөнхийн үсэг, (УБ, 2017).
С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, 3 дахь хэвлэл, Адмон, (УБ, 2013).

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, *Шүүх шинжилгээний статистик-2013*, (УБ, 2014).
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, *Шүүх шинжилгээний статистик-2017*, (УБ, 2018).

Ч.Алтаншиг, “Шүүхийн шинжилгээний байгууллагын түүхэн хөгжил, хөгжлийн чиг хандлага, үйл ажиллагаанд тулгамдсан асуудал”, *Шүүхийн шинжилгээ эмхэтгэл*, №4 (УБ, 2017).
Б.Лхагвасүрэн, “Шүүх шинжилгээний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, *Хууль сахиулахуй*, №2-02 (УБ, 2014).
Т.Очирбат, “Шүүхийн шинжилгээний байгууллага болон хууль сахиулах бусад байгууллагуудын ажлын уялдаа, эрх зүйн зохицуулалт, хүний нөөц, техник,

технологийн зарим асуудал”, *Гэмт явдалтай тэмцэх асуудал*, №2-60 (УБ, 2017).

Ж.Өнгөтхүү, “Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны орчныг боловсронгуй болгох арга зам”, *Гэмт явдалтай тэмцэх асуудал*, №2-48 (УБ, 2014).

Ж.Сайнбаяр, *Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх зүйн байдал*, (Дундговь аймгийн шүүхийн шинжилгээний алба, 2017).

Ж.Тамир, *Шинжлэн магадлах ажиллагааны удирдлага, түүнийг хэрэгжүүлэгч субъектын эрх зүйн байдлын зарим асуудал*, (УБ, 2017).

Цахим эх сурвалж

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, <http://www.legalinfo.mn/annex/details/3140?lawid=6881> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

<http://www.legalinfo.mn/law/details/88> Сүүлд үзсэн огноо: 2018.03.10.

<http://nifs.gov.mn/?/page/12.jsp> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

<http://nifs.gov.mn/?/page/14.jsp> Сүүлд үзсэн огноо: 2018.03.05.

Бусад эх сурвалж

Аймгийн шүүхийн шинжилгээний албадаас Шүүхийн шинжилгээний тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ирүүлсэн санал /2018.02.21/.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/2091 тоот албан бичиг.

Нийслэлийн прокурорын газрын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 1/4580 тоот албан бичиг.

Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлсэн мэдээлэл.

Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Судалгааны тайлангийн эмхэтгэл*, (УБ, 2017).

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2009-2017 оны үйл ажиллагааны тайлан. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга /2009.04.07/.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Д.Батжаргалын ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгаланд явуулсан албан бичигт тусгасан санал.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газрын биологийн ба химийн лабораторийн зүгээс Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлсэн мэдээлэл.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын Шүүхийн шинжилгээний тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн ажлын дэд хэсэгт ирүүлсэн мэдээлэл.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлсэн мэдээлэл.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлсэн Шүүхийн шинжилгээний байгууллагын батлагдсан төсвийн товч танилцуулга.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлсэн санал.

-----oO-----